

ТАНИЛЦУУЛГА

*Журам, гэрээний загвар батлах
тухай Хөдөлмөр, нийгмийн
хамгааллын сайдын тушаалын
төсөл боловсруулсан тухай*

Улсын Их Хурлын чуулганы 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар Нийгмийн даатгалын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/-ийг баталсан.

Нийгмийн даатгалын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/-ийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсэгт “Даатгуулагчийн хөдөлмөр эрхлэлтийн мэдээлэл, шимтгэл төлөх сарын цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын хэмжээ, шимтгэл төлөх хугацаа, талуудын эрх, үүрэг, хариуцлага, гэрээ байгуулах, гэрээний хугацааг сунгах, цуцлах, дуусгавар болгох зэрэг харилцааг зохицуулсан журам болон сайн дураар даатгуулах гэрээний загварыг хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална” гэж заасан.

Иймд хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор “Журам, гэрээний загвар батлах тухай” Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын тушаалын төсөл болон журмын төслийг тус тус боловсруулав.

Одоогоор Сангийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2020 оны 246/А/245 дугаар хамтарсан тушаалаар баталсан “Нийгмийн даатгалын сангийн анхан шатны бүртгэлийн маягт /Б-НД-10, Б-НД-10.1-10.3/-аар гэрээний загварыг, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2020 оны А/93 дугаар тушаалаар “Нийгмийн даатгалд сайн дураар даатгуулахад баримтлах журам”-ыг батлан хэрэгжүүлж ажиллаж байна.

2022 оны жилийн эцсийн байдлаар нийгмийн даатгалд сайн дураар даатгуулагчийн тоо 156.5 мянга байсан бол 2023 оны 11 дүгээр сарын байдлаар 152.4 мянга байна.

Энэхүү тушаалын төсөл батлагдсанаар нийгмийн даатгалын сангийн болон улсын төсвөөс нэмэлт хөрөнгө шаардагдахгүй.

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ